



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 06 сарын 12 өдөр

Дугаар A/52

Улаанбаатар хот

Г Зочид буудал, дэн буудал, амралтын газрын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, цуцлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам"-ын 5.1, Нийслэлийн Аялал жуулчлалын газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4588:2008" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. "Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам" болон "Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 5738:2007" стандартын шаардлагыг хангасан, энэ тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгж, иргэнд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Зонтон ХХК-ны "Ориентал" зочид буудлын 16/035, Корпорейт хотел энд конвейшн центр ХХК-ны "Корпорейт хотел энд конвейшн центр" зочид буудлын 16/022, Балт импекс ХХК-ны "Нобел" зочид буудлын 13/210, Монгол Цзэн Тай ХХК-ны "Вен жоу" зочид буудлын 15/046, Иргэн Н.Биндеръяа "Сансар" дэн буудлын 16/014, Стар интер трейд ХХК-ны "Их бүрд" зочид буудлын 15/001, Ашид Инж ХХК-ны "Ашид" зочид буудлын 16/036, Энх мөнх хүсэл ХХК-ны "Алтай" дэн буудлын 15/038, Эдельвайс Хотел ХХК-ны "Эдельвайс" зочид буудлын 13/152, Бисофт Интернэшнл ХХК-ны "Гайд" зочид буудлын 15/007 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

4. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод хяналт тавьж ажиллахыг ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д даалгасугай.

5. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэдтэй гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-д үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг хяналт, шинжилгээ, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн /Б.Огтонсууд/-д үүрэг болгосугай.



Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2017 оны 06 сарын 12  
өдрийн 15 дугаар тушаалын нэгдүгээр  
хавсралт

1117139265  
УОА0453 5284325

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2017.06.12

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрацийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Зонтон ХХК	5662966	Ориентал	БЗД-ийн 13-р хороо Нарны замын гудамж-78/2
2	Корпорейт хотел энд конвейшн центр ХХК	5159806	Корпорейт хотел энд конвейшн центр	ХУД-ийн 15-р хороо Махатма гандийн гудамж-39
3	Балт импекс ХХК	2579561	Нобел	БЗД-ийн 5-р хороо ЭТӨЧ
4	Монгол Цээн Тай ХХК	2668289	Вен жоу	БЗД-ийн 14-р хороо Намъянжунийн-19
5	Стар Интер трейд ХХК	2714388	Их бүрд	ЧД-ийн 9-р хороо Энэбишийн гудамж-46
6	Ашид Инж ХХК	5110076	Ашид	БГД-ийн 12-р хороо Өргөө гудамж-7
7	Эдельвайс хотел ХХК	2026562	Эдельвайс	СБД-ийн 1-р хороо Чин ван Г.Чагдаржавын гудамж-20
8	Бисофт интернэшнл ХХК	5086256	Гайд	СБД-ийн 6-р хороо Их сургуулийн гудамж-38

--ooOoo--

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2017 оны 06 сарын 12  
өдрийн 8:52 дугаар тушаалын  
хоёрдугаар хавсралт

1117139265  
УОА0453 5284325

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2017.06.12

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Улсын бүртгэлийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Иргэн Н.Биндэрьяа	УС69110101	Сансар	БЗД-ийн 1-р хороо Энэбишийн гудамж-13
2	Энх мөнх хүсэл ХХК	5870526	Алтай	СХД-ийн 22-р хороо Хилчиний 7/17
3	Гурван мөнх оргил ХХК	5244293	Мая хаус	СБД-ийн 19-р хороо Баянбулаг 4-411
4	Аяама Амаяа ХХК	5917972	Ийгл	БГД-ийн 23-р хороо Хувьсгалын зам-10

--ooOoo--